



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/358

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в" дэх заалт, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хар давын болон Хөндийн амны модон гүүрийн барилгын ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх	– Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд: Н.Балжинням	- Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч
Б.Ганзориг	– Мэргэжлийн хяналтын авто замын улсын байцаагч
Г.Нэргүй	– Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, дэд хурандаа
Б.Ариундолгор	- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
Б.Батболд	– Мөнххайрхан сумын Засаг дарга
Ц.Ганболд	– Мөнххайрхан сумын Засаг даргын орлогч
О.Бишгарам	– Мөнххайрхан сумын Тамгын газрын дарга
С.Оюун-Эрдэнэ	– Мөнххайрхан сумын газрын даамал

Нарийн бичгийн дарга:Ц.Сувдаа -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хар давын болон Хөндийн амны модон гүүрийн барилгын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/ – д даалгасугай.

3. Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

